



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 15 болон 16 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 04-р сарын 16-наас 04-р сарын 30-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 7 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Европын холбоо** бүсийн эдийн засгаа сэргээх зорилгоор **800 тэрбум еврогийн бондыг ирэх 5 жилийн хугацаанд гаргахаар төлөвлөж байна**. Уг бондын гуравны нэгийг ногоон бонд эзэлж байгаа бөгөөд энэ оны намраас зах зээлд арилжаалах тооцоололтой байна. Улмаар 2026 оныг дуустал жил бүр 150-200 тэрбум еврогийн бондыг гаргахаар ажиллаж байна хэмээн Европын холбооны удирдлагууд мэдээллээ.
- Euromonitor International байгууллагын энэ оны 4-р сард шинэчилсэн төсөөллөөр **дэлхийн эдийн засаг 2021 онд 5.9 хувиар, 2022 онд 4.2 хувиар өсөх төлөвтэй** байна. Энэ нь уг байгууллагын 1-р сарын төсөөллөөс 0.8 нэгж, 0.3 нэгж хувиар тус тус сайжирсан төсөөлөл юм. АНУ-ын эдийн засгийг дэмжих төсвийн багц хөтөлбөр хүлээлтээс өндөр дүнтэй батлагдсан, тус улсад вакцинжуулалт эрчимтэй үргэлжилж, 2021 оны зун гэхэд сүргийн дархлаанд хүрэх хүлээлтэй байгаа зэрэг нь өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Харин Евро бүсэд вакцинжуулалт хүлээлтээс удаан явцтай байж, цар тахлын гурав дахь давалгаа эрчээ авах хандлагатай байгаа нь төсөөллийг муутгах чиглэлд нөлөөлөв. Суурь төсөөллөөр энэ онд АНУ-ын эдийн засаг 6.0 хувиар, Евро бүс 4.0 хувиар, БНХАУ улс 8.3 хувиар өсөх тооцоололтой байна.
- **АНУ-ын эдийн засаг 2021 оны 1-р улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 6.4 хувиар өслөө**. Энэхүү өсөлт нь хөл хорио суларч, эдийн засгийн сэргэлт үргэлжилж байгаагийн дээр Засгийн газраас цар тахалтай тэмцэх багц хөтөлбөр эдийн засагт дэмжлэг болж байгааг илтгэж байна гэж АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний хорооноос мэдээллээ. Эдийн засгийн бүрэлдэхүүнээр нь задлан харвал өрхийн хэрэглээ, Засгийн газрын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол экспорт, импорт, хувийн секторын эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлтийг бууруулах чиглэлд нөлөөлөв.
- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлаг Энэтхэгийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг ВВВ-, төлөвийг сөрөг болгон бууруулав. Үүнд тус улсын гадаад өрийн дарамт болон зарим бүтцийн хүчин зүйлс нөлөөлсөн байна.



Тус агентлагийн мэдээлснээр Энэтхэгийн ДНБ 2021 онд 7.5 хувиар буурахаар байгаа бол 2022 онд 12.8 хувь, 2023 онд 5.8 хувиар тус тус өсөхөөр төсөөлжээ. Гэсэн хэдий ч цар тахлын нөлөөгөөр 2022 оны төсөөлөл буурч магадгүйг анхааруулж байна. Ковид-19 цар тахлын 2 дахь давалгаа эхэлсэн нь банк санхүүгийн салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байгааг анхааруулсан байна. Энэтхэг улсын Төв банкнаас активын чанарыг нэмэгдүүлэхэд төрийн банкууд руу 200 тэрбум рупи (ДНБ-ий 0.1%) санхүүжилт олгож байгааг Фитч агентлагийн зүгээс санхүүгийн системд үүссэн эрсдэлийг бууруулахад хангалтгүй арга хэмжээ гэж үзжээ.

- Саудын Араб, ОХУ-ын зүгээс **газрын тосны нийлүүлэлтийг ирэх гурван сард нэг өдрийн 2 сая баррелиар нэмэгдүүлэх** санаачлага гарган ОПЕС+ нэгдлийн гишүүд дэмжлээ. Түүнчлэн, газрын тосны нэг өдрийн эрэлт 6 сая баррель хүрч өсөх төсөөлөлтэй байгаа тухай ОПЕС+ мэдээлэв. Энэтхэг, Бразил зэрэг зарим улс оронд цар тахлын дэгдэлт нэмэгдэж буй хэдий ч дэлхийн эдийн засгийн өсөлт сэргэж байгаа тул газрын тосны эрэлт нэмэгдэх эерэг хүлээлттэй байгаа тухай ОПЕС+ мэдэгдээд байна. Түүнчлэн, өнгөрсөн онд буураад байсан газрын тосны эрэлт энэ оны **2-р улирлын эцэст** хэвийн түвшинд шилжинэ гэж үзэж байна. Цар тахлаас шалтгаалан ОПЕС+ улс орнууд газрын тосны нийлүүлэлтийг аажмаар, болгоомжтой нэмэгдүүлэх стратеги барих тухай ОПЕС+-ийн нарийн бичгийн дарга Мохаммад Баркиндо өөрийн твиттер хуудсаараа мэдээллээ.
- Цар тахлаас шалтгаалан 2020-2021 оны санхүүгийн жилүүдэд **Их Британийн гадаад өрийн хэмжээ нэмэгдэж**

Дэлхийн II дайнаас хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн тухай тус улсын Үндэсний статистикийн газраас мэдээллээ. Өнгөрсөн оны эхэнд гадаад өрийн хэмжээ 57.1 тэрбум фунт байсан бол энэ оны 3 дугаар сарын сүүлээр 303.1 тэрбум фунт буюу ДНБ-ий 97.7 хувьд хүрч өссөн байна. Үүнийг тус улсын Төв банкнаас энэ нь цар тахлын эсрэг зайлшгүй авах арга хэмжээ байсан төдийгүй хүлээгдэж байсан хэмжээнээс 43.3 тэрбум фунтээр бага байгаа тухай мэдээллээ.

- **ОХУ-ын Төв банк** 4-р сарын 23-ны өдөр хуралдан **бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар өсгөж 5.0 хувьд хүргэлээ**. Төв банкны мэдээлж буйгаар эдийн засгийн сэргэлт тогтвортой үргэлжилж, зарим секторууд хүлээлтээс давсан өсөлттэй байна. Мөн хэрэглээний үнийн индекс өсч, 3-р сард инфляц 5.8 хувьд хүрсний зэрэгцээ зах зээлд оролцогчдын инфляцын хүлээлт өндөр байгаа талаар дурджээ. ОХУ-ын Төв банк энэ онд инфляц 4.7-5.2 хувь болж, зорилтот 4 хувийн түвшнээс өндөр байх, эдийн засаг нь 3-4 хувиар өсөхөөр төсөөлж байна.
- **Японы Төв банк** тус улсын эдийн засгийн өсөлтийн төсөөллөө 0.1 хувиар сайжруулж 4 хувь<sup>1</sup> болгожээ. Мөн инфляцын 2 хувийн зорилтот түвшинд 2023 он хүртэл хүрч чадахааргүй байгааг мэдээлсэн байна. Төв банкны Ерөнхийлөгч Харухико Куродагийн бүрэн эрхийн хугацаа дуусч байгаа бөгөөд тэрээр инфляцын 2 хувийн зорилтот түвшинд хүрэхэд тодорхой хугацаа шаардлагатай бөгөөд мөнгөний зөөлөн бодлогын нөлөөгөөр инфляцын зорилтод хүрэх боломжтойг хэвлэлийн хурлын үеэр онцоллоо. **Мөн Японы Төв банк 4-р сарын 27-ны хурлаар**

<sup>1</sup> Энэ оны 3 дугаар сараас ирэх оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд дахь өсөлтийн төсөөлөл.

бодлогын хүүгээ хэвээр хадгалахаар шийдвэрлэв.

- **Блүүмберг агентлаг БНСУ-ын эдийн засгийн 2021 оны төсөөллийг 3.9 хувиас 4.4 хувь болгон шинэчиллээ.** Тус улсын ДНБ 2020 оны 4 дүгээр улиралд 1.2 хувиар буураад байсан бол энэ оны 1-р улиралд 1.1 хувийн өсөлтийн хүлээлтээс давж 1.8 хувьд хүрэв. Шинжээчдийн дүгнэлтээр гадаад орчин энэ оны турш сайжрах хүлээлттэй байгаагийн дээр эдийн засгаа сэргээх хөтөлбөр, вакцинжуулалтын нөлөөгөөр БНСУ-ын дотоодын эдийн засаг сэргэнэ гэж төсөөлж байна. Мөн өнгөрсөн оны 4-р улиралтай харьцуулахад 2021 оны эхний улиралд үйлдвэрлэл 3.9 хувь, экспорт 4.5 хувиар тус тус өсчээ.

*Эх сурвалж:*

1. EuroMonitor International, [Global Economic Outlook: Q2 2021](#)
2. Kyodo news, [BOJ chief likely to miss 2% inflation target during his term to 2023](#)
3. BEA, Gross Domestic Product, First Quarter 2021 (Advance Estimate)
4. Bloomberg, [EU Lays Out \\$1 Trillion Debt Plan to Challenge Treasuries](#)
5. Bloomberg, [Fitch Affirms India At 'BBB-', Outlook Negative](#)
6. Bloomberg, [OPEC+ Confirms Plan to Gently Hike Supply as Demand Recovers](#)
7. Bank of Russia, [The Bank of Russia increases the key rate by 50 bp to 5.00% p.a.](#)
8. Financial Times, [Covid response pushes UK borrowing to highest since second world war](#)
9. ICIS, [South Korea's Q1 GDP grows by 1.8% on strong manufacturing, exports](#)
10. Deloitte, [Weekly global economic update](#)
11. Korea insight, [4%-Plus Growth for 2021 After 1Q GDP Beat](#)

## 2

## БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын эдийн засаг 2021 оны 1-р улиралд өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар өсөв.** Тодруулбал, хөдөө аж ахуйн салбар өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар, аж үйлдвэрлэл 24.4 хувиар, үйлчилгээний салбар 15.6 хувиар тус тус өсчээ. Аж үйлдвэрийн салбар эрчимтэй тэлэхэд экспорт 49 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Хэдийгээр жилийн өсөлт өндөр харагдаж байгаа ч ДНБ-ий улирлын өсөлтийг авч үзвэл өмнөх улирлаас 0.6 хувиар буюу харьцангуй бага хувиар өссөн байна. Үүнд БНХАУ-ын Засгийн газраас өрийн түвшинг бууруулах, зээлийн өсөлтийг хязгаарлах, үл хөдлөх хөрөнгийн хөөсрөлт бий болохоос сэргийлэх бодлого баримталж, төсвийн дэмжлэгээ багасгаж байгаа нь нөлөөлжээ.
- **БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 2021 онд өмнөх төсөөллөөс**

**0.2 нэгж хувиар буурахаар байгаа ч илүү тэнцвэртэй өсөлт ажиглагдах төлөвтэй.** БНХАУ-ын эдийн засаг 2021 оны 1-р улиралд Блүүмберг агентлагийн хүлээлтээс доогуур буюу жилийн 18.3 хувиар өссөн бол 2-р улиралд 8.2 хувь, 3-р улиралд 6.8 хувь, 4-р улиралд 5.6 хувиар тус тус өсч, улмаар 2021 онд жилийн 9.1 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Тус байгууллагын 3-р сарын төсөөлөлд БНХАУ-ын эдийн засаг 2021 оны 1-р улиралд 20.3 хувь, 2-р улиралд 8 хувь, 3-р улиралд 6.5 хувь, 4-р улиралд 5.6 хувиар тус тус өсөн, 2021 онд жилийн 9.3 хувиар өсөхөөр төсөөлж байсан юм. Аж үйлдвэрлэлийн сэргэлт эрчтэй байгаа хэдий ч үйлчилгээний салбарын сэргэлт хүлээлтээс 2 сараар хойшилж, ирэх улирлаас идэвхжил нь нэмэгдэх төлөвтэй байна. Тархалтын тохиолдол оны эхэнд нэмэгдсэн, Цагаан сарын

үеэр аялал хязгаарласан нөлөөгөөр эдийн засгийн гуравдагч салбар болох үйлчилгээний салбарын эрэлт татарч, тус салбарын өсөлт 2021 оны 1-р улиралд 4.7 хувь гарсан нь 2020 оны 4-р улирлын 6.7 хувийн өсөлт, цар тахлын өмнөх 2019 оны түвшин болох 7.2 хувийн өсөлтөөс бага үзүүлэлт байлаа. Ирэх сарын эхэнд тохиох “Qingming” баярын үеэр аялах зорчигчдын тоо цар тахлын өмнөх түвшний 90 хувьд хүрч нэмэгдэх төлөвтэй бөгөөд кино театрын борлуулалт, зочид буудлын захиалгын тоо эрс нэмэгджээ. ЗГ-аас иргэдийн хэрэглээг нэмэгдүүлж, дотоод эрэлтийг эрчимжүүлэх зорилгоор “5-р сарыг хэрэглээний сар” болгон зарлаад байна.

- **БНХАУ-ын албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс** 3-р сард 51.9 байсан бол 2021 оны 4-р сард хүлээлтээс давж, 52.0-д хүрэх төлөвтэй байна. Мөн экспортод суурилсан Caixin боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс 3-р сард 50.6 байсан бол 4-р сард 50.8 хүрэх, албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн бус PMI индекс 3-р сард 56.3 байсан бол 4-р сард хүлээлтээс нэмэгдэн 56.8 хүрч нэмэгдэх төлөвтэй байна. Үйлдвэрлэлийн PMI индекс ийнхүү хүлээлтээс өндрөөр өсөхөд үйлдвэрлэл, шинэ захиалгын хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Гадаад эрэлтийн идэвхжлийг илэрхийлдэг Өмнөд Солонгосын экспорт 4-р сарын эхний 20 хоногт өмнөх оны мөн үеэс 45.4 хувиар өсч, 2011 оны 2-р сараас хойшхи хамгийн өндөр өсөлт ажиглагдлаа. Мөн АНУ-ын үйлдвэрлэлийн салбарын PMI индекс 3-р сард 64.7-д хүрч 1983 оноос хойшхи хамгийн өндөр түвшинд хүрээд байна. АНУ болон Евро бүсийн PMI индекс хүлээлтээс өндөр өссөнөөр БНХАУ-ын экспортод төвлөрсөн салбаруудад эерэгээр нөлөөлсөн байна.

БНХАУ-ын үйлдвэрлэлийн бус PMI индекс өмнөх сараас нэмэгдэхэд барилгын салбар эрчимжсэн, өрхийн хэрэглээний идэвхжил нэмэгдсэн нь нөлөөлжээ. Түүнчлэн 10 хотын метро болон замын хөдөлгөөний систем дэх зорчигчдын тоо 4-р сард цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрч, энтэртайнмент болон катеринг үйлчилгээний идэвхжил нэмэгдэж байна.

- **Үндсэн хөрөнгийн (fixed asset investment) хөрөнгө оруулалт** 2021 оны эхний 3 сард 9.6 их наяд юаниар буюу жилийн 25.6 хувиар өсчээ. Эдийн засгийн идэвхжлийг даган хувийн сектор дэх хөрөнгө оруулалт 5.5 их наяд юаниар буюу жилийн 26.0 хувиар өсөв. Мөн боловсруулах салбар дахь хөрөнгө оруулалт жилийн 29.8 хувиар нэмэгдсэн бол дэд бүтцийн барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 29.7 хувиар нэмэгдлээ.
- **БНХАУ-ын дотоодын үл хөдлөх салбарын хөрөнгө оруулалт** 2021 оны эхний 3 сард 2.8 их наяд юань хүрч жилийн 25.6 хувиар өссөнөөс орон сууцны хөрөнгө оруулалт жилийн 28.8 хувиар өсч, 2.1 их наяд юанд хүрч сэргэлт хадгалагдаж байна.
- **Автомашинны худалдаа** 2021 оны эхний 3 сард 6.5 саяд хүрч, жилийн 75.6 хувиар нэмэгдсэн бол автомашинны үйлдвэрлэл эхний 3 сард 6.4 саяд хүрч жилийн 81.7 хувиар нэмэгдэв. Үүнээс зөвхөн 3-р сард 2.5 сая автомашин үйлдвэрлэсэн нь өмнөх сараас 67.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 69.8 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Мөн автомашинны худалдаа 3-р сард жилийн 74.9 хувиар өсч 2.5 сая нэгж борлуулагдсан нь өмнөх сараас 73.6 хувиар нэмэгдсэн дүн юм.
- **2021 оны эхний 3 сард БНХАУ-ын Монгол Улсаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ** 6.08 сая тонн буюу





өмнөх оны мөн үеэс 123.2 хувиар нэмэгджээ. Мөн хугацаанд БНХАУ Австралиас коксжих нүүрс импортлоогүй бол Канадаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 31.6 хувиар өсч 1.97 сая тоннд, ОХУ-аас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 8.5 хувиар өсч, 1.43 сая тоннд тус тус хүрчээ.

- **БНХАУ-ын гангийн импорт** 2021 оны эхний 3 сард нийт 3.7 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар нэмэгдсэн бол **3-р сард** 1.3 сая тонн байсан нь өмнөх оны мөн үеэс **15.8 хувиар нэмэгдсэн дүн байв.**
- Монгол улсад цар тахлын тархалт нэмэгдэж буйн улмаас БНХАУ-ын гааль

Монголоос импортлох нүүрсний тээврийг энэ сарын турш хатуу хязгаарласан хэвээр байна. Ганцмод боомтоор нэвтрэх машины тоо 4-р сарын 10-ны байдлаар 19 байсан бол 4-р сарын 23-ны өдөр 65 байв.

**Эх сурвалж:**

1. *China Insight: Cutting GDP forecast but 2021 looks more balanced, Bloomberg*
2. *China Preview: PMIs set to show acceleration in April activity, Bloomberg*
3. *Fenwei Coal weekly update, Sxcoal.com*
4. *Fenwei Coking coal monthly, Sxcoal.com*

3

**МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН  
ӨӨРЧЛӨЛТ**

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/04/28	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
<b>Зэс</b>	9880	0.0%	4.9%	11.4%	27.5%	90.2%	Дэлхийн нийтээр КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж буй нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж байгаа болон БНХАУ-ын ногоон хөгжлийн бодлогыг дагасан аж үйлдвэрлэлийн салбарын өсөлт нэмэгдэх төлөв нь зэсийн үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
<b>Төмрийн хүдэр</b>	185	0.0%	5.7%	18.4%	21.5%	126.0%	БНХАУ улс энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтийн улмаас төмрийн хүдрийн эрэлт өндөр байх төлөвтэй. Мөн БНХАУ-ын агаарын бохирдлын эсрэг хэрэгжүүлж буй бодлого хуучирсан тоног төхөөрөмжтэй үйлдвэрүүдэд хязгаарлалт тавьж байгаа нь үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
<b>Алт</b>	1782	-0.3%	-0.4%	3.7%	-6.5%	3.7%	Хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа нь алтны эрэлт, үнэ өндөр байхад нөлөөлж байна. Гэвч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилэн зах зээлд дээрх тодорхой бус байдлыг бууруулах нөлөө давамгайлж алтны үнэ өмнөх долоо хоногоос буурахад нөлөөллөө.
<b>Газрын тос (Брент)</b>	67.2	1.0%	3.8%	4.5%	32.9%	201.3%	ОПЕК+-ийн нэгдэл нийлүүлэлтээ хүлээлтээс бага хэмжээгээр өсгөхөөр шийдвэрлэсэн, БНХАУ, АНУ-ын эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайн гарсан нь газрын тосны үнийг өмнөх долоо хоногоос өсгөх чиглэлд нөлөөлж байна. Түүнчлэн ОПЕК+-ийн нэгдэл энэ онд газрын тосны эрэлт 6.6 хувиар нэмэгдэх төсөөлөлтэй байгаа нь үнийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлж байна.